

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ТАЙЛАН

Дундговь аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь Санхүү бүртгэлийн тасаг, Үйлчилгээний тасаг, хяналт шалгалт- дотоод аудитын тасаг гэсэн гурван тасагтай бөгөөд үндсэн 35 гэрээт 3 ажилтантайгаар нийт 38 орон тоонд багтаан ажиллаж байна. “Бид ДААТГУУЛАГЧИЙНХАА итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилго тавин хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган хэрэгжүүлэн ажиллаж



1. ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу байгууллагын баримт бичгийг батлагдсан стандартын дагуу бичиж, хөтлөх ёстой бүртгэлүүдийг бүрэн хөтөлж ажиллаж байна.


2023 оны жилийн эцсийн байдлаар дээд шатны байгууллага болон НДЕГ, Аймгийн Засаг Даргаас 64 тушаал, тогтоол, захирамж ирсэн бөгөөд холбогдох албан хаагчдад хүргүүлж шийдвэрлэсэн. Мөн хэлтсийн хэмжээнд ирсэн, явсан бичгийг албан хаагчдад цахимаар шилжүүлж хэвшсэн бөгөөд 2023 онд ирсэн бичиг 409, явсан бичиг 374, өргөдөл 42 бүртгэгдсэн. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хоногийг тооцоолоход 14 хоног байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг заасан хугацаанд НДЕГ-ын ДАМГ-т, улирал тутамд аймгийн төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Иргэдээс ирж буй өргөдлийн ихэнх нь тэтгэвэр тогтоолгон ажиллаж буй иргэд ажилласан жилийн нэмэгдэл бодуулж тэтгэврээ нэмэгдүүлэх, өндөр насны тэтгэврээ дахин хянуулж бодуулах, тухайн, иргэнийг хүүхэд асрэх чөлөөтэй байх хугацаанд НДШ-ийг ажиллаж байсан байгууллага нь төлөөгүй тул нөхөн төлүүлэх тухай зэрэг хүсэлтүүд давамгайлж байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны асуудлаар буюу хэлтсийн даргын “А” тушаал 31, боловсон хүчний асуудлаар буюу “Б” тушаал 50 гарсан бөгөөд биелэлтийг тооцон ажиллаж байна.

2023 оны 02 дугаар сард ERP цахим шилжилттэй холбоотойгоор аймгийн төрийн захиргааны хэлтэст үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг хянуулан үнэлүүлсэн. Энэхүү үнэлгээтэй холбоотой төлөвлөгөө гарган өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

1.2 Цахим сурталчилгаа

Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах ажлын хүрээнд Дундговь Нийгмийн даатгалын хэлтэс пэйж хуудсаар 110 постер мэдээ оруулж хандалтын тоог 2200-д хүргэж аймаг орон нутгийн хандалт ихтэй группт мэдээллийг тогтмол оруулж хэвшсэн.



1.3 АЖИЛ ОЛГОГЧ ДААТГУУЛАГЧИД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ

1. "Даатгалтай ирээдүй" нийгмийн даатгалын анхан шатны мэдлэг олгох сургалт

Сайнцагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулах зорилготой "Даатгалтай ирээдүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын 6 сургуулийн 210 сурагч, Сайн дур, Эрүүл мэндийн даатгал, Цахим үйлчилгээг сурталчилж ажилласан.



1.4 МАЛЧИН, ХХЭ НАРТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, мэдээ мэдээллээр хангах, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор Дундговь аймгийн 9 сумын малчдын зөвөлгөөнд оролцож 3500 малчидтай уулзаж нийгмийн даатгалд даатгуулах ач холбогдлын талаар мэдээлэл хүргэсэн. Сайн дур, Эрүүл мэндийн даатгал, цахим үйлчилгээг сурталчилж ажилласан.



1.5 ШИНЭЧЛЭГДСЭН ХУУЛЬ ТОГТООМЖ ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ, ХАМРАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ"Үүнд:

8 төрийн албан байгууллагын 150 албан хаагчдад шинээр батлагдсан нийгмийн даатгалын багц хуулийн талаар мэдээлэл өгч ажилласан.



Ажил олгогч, даатгуулагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд нийгмийн даатгалын тухай багц хуулийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж хэрэгжилтийг ханган нийт 3820 иргэд даатгуулагч нартай биечлэн уулзаж сургалт, мэдээллийг өгч ажилласан. сургалт зохион байгуулсан дэлгэрэнгүй тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлсэн.

1.6 Архив албан хэрэг хөтлөлт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 сарын 22 өдрийн А/190 дугаар тушаалыг тус хэлтсийн даргад танилцуулан 2022 оны 01 сарын 30 өдөр А/05 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй хэлтсийн салбарын хэмжээнд архивд хадгалагдаж буй санхүүгийн баримтад нягтлан шалгалт хийх, эмхлэн цэгцлэх, хадгалах, устгах, хамгаалах ажилд хяналт тавьж шалгах зөвөлгөө зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг томилон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус ажлын хүрээнд архивын өрөөний эмх цэгц, хадгалалт хамгааллалтыг сайжруулах баримтыг эмхлэн цэгцлэх, ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



Архивын лавлагааг аймаг дүүрэг рүү хүсэлт явуулж цахимаар лавлагааны хариуг авах ажил саадгүй хэрэгжиж байгаа бөгөөд шимтгэл төлөлтийн архивын лавлагааг иргэд даатгуулагчдаас хүлээн авсан хүсэлт 11, бусад хэлтсээс ирсэн хүсэлт 56, эх баримтаас 314, 1991-1994 оны ААНБ-н шимтгэл төлөлтийн лавлагаа 95, нөхөн тооцох лавлагаа 67 нийт 543 НДШ төлөлтийн лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн байна Мөн нийгмийн даатгалын байгууллагаас гарах бүхий л төрлийн лавлагааг цахимаар авах бүрэн боломжтойг сурталчилж ажиллалаа.

1.7 Хүний нөөц:

Тус хэлтэс нь 38 батлагдсан орон тоотойгоос одоогоор 35 орон тоотой буюу Сайхан-Овоо, Хулд, Гурвансайхан сум байцаагчгүй ажиллаж байна. Уг сул орон тоог нөхүүлэхээр төрийн албаны салбар зөвлөлд материалыг нь хүргүүлэн ерөнхий болон тусгай шалгалтын зарыг зарлуулсан.

Ковид-19 хуулийн үйлчлэл дууссан болон өөрийн хүсэлтээр нийт 9, тэтгэврийн насанд хүрсэн 2 нийт 11 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, сүлжээний инженерийг төрийн үйлчилгээний албан тушаалд, бичиг хэрэг, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, сан хариуцсан мэргэжилтэн нарыг ТАСЗ-ийн тогтоолын дагуу эгүүлэн томилсон. Шинээр 6 албан хаагч томилогдсоноос 1 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 27 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын “Зарим албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох тухай” 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/92 дугаар захирамж гарсан. Тус захирамжаар тус хэлтсийн 9 байцаагчид төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг ахиулан олгохоор шийдвэрлэсэн. Эдгээр албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож эхэлсэн. Монгол Улсын ХНХ-ын сайдын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох тухай” А/214 дугаар тушаалаар хэлтсийн 5 байцаагчид эрх баталгаажуулан олгож 1 байцаагчид эрх шинээр олгосон.

Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа программ болох ХНУМТ цахим систем, GREEN ERP цахим систем, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд хүний нөөцийн мэдээллийг бүрэн оруулж өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийж ажиллаж байна.

1.8 Сургалт:

Аймгийн ЗДТГ болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан танхимын 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 87 албан хаагч, НДЕГ-аас зохион байгуулсан цахим болон танхимын 7 удаагийн сургалтад давхардсан тоогоор 81 албан хаагч хамрагдаж өөрсдийн мэдлэг, ур чадвараа зохих түвшинд дээшлүүлээд байна. Мөн хэлтсээс зохион байгуулсан 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 58 албан хаагч, Төрийн албаны зөвлөлийн 12 удаагийн 7:4:10 вебинар сургалтад 34 албан хаагч хамрагдсан.



2.ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- (<http://10.9.0.5/monitoring>)-д тулгуурлан 2023 оны 13 төрлийн 1287 мэдээлэл зөрчилтэй мэдээллийг шалгаж зөрчлийг арилгасан

Үүнд:

1. Цалин өөрчилсөн/АО/- 254
2. 01 код давхардсан -333
3. РД нэгтгэсэн-7
4. Ажил хийдэг тэтгэвэр авагч -103
5. Цалин өөрчилсөн/даатгуулагч/-170
6. Цалин устгасан-109
7. АЖ тэтгэмж авах хугацаандаа ажилласан-96
8. АЖ тэтгэмж цалинг хянах-8
9. АЖ тэтгэмж эрхийн нөхцөл хянах 2
- 10.ЖА тэтгэмж эрхийн нөхцөл хянах-7
- 11.ЖА тэтгэмж цалин хянах-131
- 12.Тэтгвэр тогтоосон цалин хянах-9
- 13.Шимтгэл-даатгуулагчийн төрөл код буруу-58 зэрэг зөрчлүүдийг арилгаж хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллаж байна.


2023 онд аж ахуй нэгжийг шалгах төлөвлөгөөт шалгалтыг хэлтсийн даргын удирдамжийн дагуу 4 сарын 10-наас 9 сарын 30 өдрийн хооронд хийж 90 аж ахуй нэгжийг шалгасан. Шалгалтын зорилго нь нийгмийн даатгалтай гэрээтэй аж ахуй нэгжид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлээс уридчилан сэргийлэх үүссэн зөрчил дутагдлыг арилгахаар хяналт шалгалтийг хийсэн. Мөн

ажил олгогчийн тоот даатгуулагчийн өргөдөл гомдлын хүрээнд 27 аж ахуй нэгжийг шалгаж нийт 156,8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавьж 1 аж ахуй нэгжийн 148,5 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг шүүхээр баталгаажуулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн авлага барагдуулах тал дээр хамтран ажиллаж байна.

2022-2023 онуудад олгосон ажилгүйдлийн тэтгэмж дээр цалин давхардуулж авсан 19 даатгуулагчийн 8,0 сая ,илүү олгосон 5 тэтгэвэр авагчид 9.1 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавьж актыг 100% барагдуулсан байна. 11 аж ахуй нэгжид нийт 5,9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

НДШ-ийн 2023 оны эхний үлдэгдэл 743.3 сая төгрөгийн авлагатай байснаас 526,7 сая төгрөг барагдуулсан байна. (График-1). 120 ба түүнээс дээш хоногийн насжилттай шимтгэлийн авлагын судалгааг гарган судалгаанд үндэслэн 1 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлж 1 аж ахуй нэгжийн 148,3 сая төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байна.

График 1



2.1 Тэтгэвэр тогтоолт, олголт:

Дотоодын хяналт шалгалтаар сумын тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт, Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг цахим болон цаасан хэлбэрээр шалгаж 9.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж гарсан төлбөрийг 100% барагдуулж ажилласан байна. Өмнөх оны тэтгэврийн улсын байцаагчийн актын 6.1 сая авлагаас 4.3 сая төгрөгийг актыг барагдуулсан байна.

Тус хэлтэст 8413 тэтгэвэр авагчид тэтгэвэр авч байна. Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргасан үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж тооллогод хяналт шалгалт хийж ажилласан. 2023 онд шинээр тэтгэвэр тогтоолгосон 493 / өн-376 ТД-98 ТА-19 /тэтгэвэр авагчийн тогтоолт олголтод хяналт тавьж ажилласан.

2.2 Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн тухай санал гомдол, өргөдлийг бүртгэж Прокурорын газарт сар бүрийн 28-нд мэдээг тогтмол хүргэж ажиллаж байна. 2023 оны байдлаар 1 ААН байгууллагад хяналт шалгалт хийж зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1.6 сая төгрөгийн шимтгэлтийг төлүүлж 250.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж, нөхөн төлбөрийг бүрэн барагдуулан ажилласан байна

2.3 Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын талаар

Монгол Улсын засгийн газрын 67 тоот тогтоолоор Эмнэлэг хөдөлмөрийн магадлах дүрэм шинэчлэн баталсан, “Эмнэлгийн хуудас олгох, хянах тухай” НДЕГ-н даргын 2021 оны А/38 тоот тушаал, “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ” –ийн тухай ЭМС, ХНХС-ийн А/758 А197 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх талаар Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч нар болон шинээр ажилд орсон сум өрхийн эмч нарт 10 удаагийн цахим сургалт зохион байгуулан давхардсан тоогоор нийт 55 эмч хамрагдсан.

Аймгийн Эрүүл мэндийн газар болон нэгдсэн эмнэлэгтэй хамтран осол, гэмтэл болон хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг аймгийн нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд зохион байгууллаа. Сургалтанд нийт 50 иргэн хамрагдсан.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 2022 оны 04 сарын 12 ны өдрийн А/66 тушаалаар шинэчлэгдэн батлагдаж ЭХМК-н дарга эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах талаар ЭХМК болон ЭХК-ийн дарга гишүүдэд зөвлөмж хүргүүлснээр ЭХМК-ийн гишүүдийн хуралд оролцох оролцоо, үүрэг хариуцлагыг жигдрүүлэн ажиллаж шийдвэр гаргалтанд гишүүн бүрийг оролцуулан олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Хурлын явцад гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийг хуваарилж хуралд оролцох оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэн ажилласнаар хурлын чанар дотоод үйл ажиллагаа жигд сайжирсан. Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамаарал бүхий этгээдийн мэдэгдэх хуудас”-ыг ЭХМК-ийн гишүүдээр бөглүүлэн үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн хэвшсэн.

Нарийн мэргэжлийн эмч нар болон өрх, сумын эмч нар ХЧА-тай иргэн даатгуулагчид тохирсон эрүүлжүүлэх төлөвлөгөөг гаргаж тухайн төлөвлөгөөний дагуу хийгдсэн эмчилгээ үйлчилгээний дагуу ЭХК болон ЭХМК үр дүнг тооцож ажилснаар эрүүлжүүлэх арга хэмжээ чанаржиж байна. Эмчлэн эрүүлжүүлсэн 98 иргэн даатгуулагч байна.

2023 онд нийт 50 удаа хуралдаж 1326 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн 108 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг цуцалж, 120 иргэн шинээр тогтоон 1108 иргэний хөдөлмөрийн чадвар

алдалтын хувь хугацааг сунгаж шийдвэрлэсэн бол 35 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын үндэслэл хангалтгүй шалтгаанаар буцаасан байна.

2023 онд хөдөлмөрийн чадвар түр алдалтын 895 эмнэлгийн хуудсыг цахимаар, 34 эмнэлгийн хуудсыг цаасаар, жирэмсэн амаржсан 526 эмнэлгийн хуудсыг цахимаар, 33 эмнэлгийн хуудсыг цаасаар хянан тэтгэмжийн байцаагчид шилжүүлсэн байна. Цахимаар эмнэлгийн хуудас бичих аргазүйн зөвлөмжийг эхний хагас жилд 7 эрүүл мэндийн байгууллага /Хулд, Баянжаргалан, Дэлгэрхангай, Гурвансайхан, Цагаандэлгэр, Өндөршил, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төв/-ын эмч нарт, хоёрдугаар хагас жилд 3 эрүүл мэндийн төвийн /Өлзийт, Нэгдсэн эмнэлэг, Луус/ эмч нарт тус тус утсаар зөвлөмж өгч ажиллалаа.

2023 оны эхний хагас жилд нүд, чих хамар хоолой, дотор, мэдрэлийн нарийн мэргэжлийн эмч нарын дунд, 2023 оны хоёрдугаар хагас жилд мэс үасал, гэмтэл судлалын нарийн мэргэжлийн эмч нарын дунд ижил мэргэжилтний үзлэгийг тус тус зохион байгуулсан. Ингэснээр дээрх мэргэжлийн чиглэлээр эмнэлэг хөдөлмөр магадлах үйл ажиллагаанд оролцож буй эмч нарын зөрүүтэй ойлголт арилан, маргаантай асуудлыг шийдвэрлэн ажилласан.

3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГЫН ТАЛААР:

2022 оны шимтгэлийн авлага 743,3 сая төгрөг, үүнээс 544,7 сая төгрөгийг санд төлүүлж 2023 онд үүссэн урсгал авлагыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн сумдын байцаагч нарт аяны хүрээнд шимтгэлийн авлагыг нэмэгдүүлэхгүй бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар чиглэл хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх” журмын дагуу авлага барагдуулах дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Шимтгэлийн авлага барагдуулахаар давхардсан тоогоор 1852 ажил олгогчтой утсаар холбогдож, мөн мессежээр-982 удаа нийгмийн даатгалын шимтгэлийг цаг хугацаандаа төлөхийг шаардан мэдээлэл мэдэгдэлийг хүргүүлж ажиллалаа.
- 26 ажил олгогчийн эзэн, нягтлан бодогчтой уулзалт хийж шимтгэлийн цаг хугацаанд нь төлж даатгуулагчдын эрх ашгийг хамгаалж ажиллахыг зөвлөсөн.
- Төсөвт байгууллагын авлагын судалгааг сар бүр 11 удаа гаргаж Төрийн санд хүргүүлж хамтран ажилласан.

Эдгээр ажлуудын үр дүнд шимтгэлийн орлого авлагын эзлэх хувь 8.2%-тай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжсэн хугацаандаа төлөөгүй шимтгэлд оногдуулсан акт алдангийн авлага 148.3 сая төгрөг байна.

2022 оны жилийн эцсээр 70 ажил олгогч байгууллагын 742.3 сая төгрөгний авлагаас 2023 оны 11 сарын байдлаар 43 ажил олгогч байгууллагын 526.7 сая төгрөгний шимтгэлийн авлагыг төлүүлж авлага барагдуулалт 70.9%-ийг барагдуулсан байна. Барагдаагүй үлдсэн 23 ажил олгогчийн 215.6 сая төгрөгийн авлагтай байна. Үүнээс 1 байгууллагын 89.3 сая төгрөгийн авлагыг ШШГ байгууллагад шилжүүлээд байна.

3.1 Хамралтын талаар:

2023 онд 26 ажил олгогч шинээр нийгмийн даатгалд хамруулах төлөвлөгөөтэйгөөс шинэ ажил олгогч -23, шилжиж ирсэн-4, үйл ажиллагаа сэргэсэн-3 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулсан ба нийт 530 аж ахуй нэгж байгууллага байна.

Харьцуулалт хийсэн хугацаа	Нийт ажил олгогчийн тоо	Албан журмын даатгуулагчдын тоо	Шинээр хамрагдсан ажил олгогчийн тоо
2021.12.31	510	6076	17
2022.12.31	527	5808	29
2023.12.01	530	6935	27
Өсөлт бууралт	100%	119%	93%



3.2 Тайлан хүлээн авалтын талаар:

Монгол улсын үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ний А/73 тоот тушаал, Сангийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 сарын 22-ний өдрийн А/182 дугаартай хамтарсан тушаалаар, Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн багц 34 маягт нөхөх заавар шинэчлэгдэн батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг маягтын өөрчлөлтийн талаар мэдээллийг 514 ажил олгогч байгууллагын 5994 албан журмын даатгуулагчидад байгууллагын нягтлан бодогч нараар нь дамжуулан хүргэсэн. Мөн dundgovi.go.mn Facebook фээж хуудас болон мэдээллийн сувгаар мэдээлэл хүргэж ажиллалаа.

[НД7,НД8 МАЯГТ](#)
[ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ](#)
[ЗАГВАР EXCEL ФАЙЛ](#)
[ЗАГВАР XML ФАЙЛ](#)

[АЖИЛ МЭРГЭЖЛИЙН КОДЫН ТАЙЛБАР](#)
[БАЙРШЛЫН КОДЫН ТАЙЛБАР](#)
[УЛСЫН КОДЫН ТАЙЛБАР](#)

Эмнэлгийн хуудсыг цахимжууллаа:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын ... тоот хамтарсан тушаалын дагуу эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлж, энэхүү цахим системд "Эмнэлгийн хуудас" цэс нэмлээ. Ажил олгогч нь эрүүл мэндийн байгууллагаас цахимаар ирсэн эмнэлгийн хуудсыг даатгуулагч тус бүрээр бодох, эмнэлгийн хуудас болон тайлангаа хэвлэн авч баталгаажуулах боломжтой боллоо.

Архангай
 Ажил олгогчийн дугаар
 Хэрэглэгчийн нэр
 Хэрэглэгчийн нууц үг

Алдаатай буюу зөрүүтэй мэдээлэл байвал буцааж мэдээллийг бүрэн засуулсны дараа баталгаажуулалт хийж хэвшсэн байна. 2023 оны 1 сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөн. Мөн тайлан хүлээн авч баталгаажуулах хуулийн хугацааг баримталан ажиллаж байна.

2023 онд 28 ажил олгогчоос тайланд засвар оруулах хүсэлт ирснээс шүүхийн шийдвэрээр 2, цалингаа буруу шивсэн 10, даатгуулагчийн төрөл код буруу шивсэн 16 ажил олгогч дээр мэдээллийг засварлаж 5680,7 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

3.3 Мэлээллийн сан бүрдүүлэлтын талаар:

Ажил олгогч байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хэвлэн авч ажил олгогчийн хавтасыг баяжуулж мэдээллийн баазад нэг бүрчлэн тулгалт хийж мэдээллийг үнэн зөв бүрэн оруулсан. Алдаатай буюу зөрүүтэй мэдээлэл байвал буцааж мэдээллийг бүрэн залруулсны дараа баталгаажуулалт хийж хэвшиж байна.

3.4 Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэлт, хамралтын төлөвлөгөөний биелэлтийн талаар:


2023 онд 0-3 хүртэлх настай хүүхэдтэй сайн дурын даатгуулагч эх 359 иргэний 81,9 сая төгрөг бусад эх 398 иргэний 61,5 сая төгрөг нийт 679 даатгуулагчийн 143,4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн эхчүүд өөрөө төлөх 50 хувийн шимтгэлээ төлж үлдсэн 50 хувийн шимтгэлийг тэтгэмжийн сан болон улсын төсвөөс төлүүлж эхийн хамралтын төлөвлөгөө 70% -ийн биелэлттэй байна.

СДД эх хамралт		
2023 онд бүтэн жил		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн %
345	359	104%

Бусад эх хамралт		
2023 онд бүтэн жил		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн %
748	398	54%

Сайн дурын даатгалд 4005 иргэний 2400,0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс Нийт 3785 иргэний 2271,9 сая төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөө 94,67%-ийн биелэлттэй байна. Жилийн эцэст орлогын төлөвлөгөө 100 хувь биелэнэ.

Хамралт		
2022 онд		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн%
2155	2669	124 %
2023 онд		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн %
4005	3785	94,51%



4.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР:

4.1Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх талаар


Нийгмийн даатгалын сангуудад 2023 онд тодотгосон төлөвлөгөөгөөр 22676,0 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө батлагдаж ирсэн. Орлогын төлөвлөгөөг сум, ажил олгогч хариуцан ажиллаж байгаа байцаагч бүрээр тухайн сумын суурин хүн ам, ажил олгогч, сайн дурын даатгуулагчийн тоо, өмнөх жилүүдэд санд оруулсан орлогын гүйцэтгэл зэрэг статистик үзүүлэлтүүдийг харгалзан хуваарилж сар бүр жигд ханган биелүүлэх үүрэг даалгавар өгч ажиллаж байна. 2023 оны ХБГ-ээр тооцоход санд 22684,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 100%-тай байна. Оны эхнээс сар бүр 97,1-100,0 %-тай байна. Санд орсон нийт орлогын 78,7 хувийг ажил олгогч, албан журмын даатгуулагчаас, 20,9 хувийг СДД-аас, 0.4 хувийг бусад орлогоос бүрдүүлсэн байна..

НДСангуудын орлогын төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:
/сая төг/

Ц/д	Сангууд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Тэтгэвэр	19115,2	19117,3	100,0
2	Тэтгэмж	1964,4	1966,9	100,0
3	ҮОМШӨ	1237,7	1239,9	100,0
4	Ажилгүйдэл	358,7	360,2	100,0
Дүн		22676,0	22684,3	100,0

Дээрх хүснэгтээс харахад сан тус бүр дээр 100 хувиар орлогын төлөвлөгөө биелсэн байна.

Орлого /сая төг/		
2022 он		
Төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлтийн %
15871,6	15515,7	97,8%
2023 он		
Биелэлт	Биелэлтийн %	Биелэлтийн %
22684,3	100,0%	100,0%




Нийгмийн даатгалын сангуудын орлогыг бүрдүүлж, хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган орон нутагтаа НДТХууль тогтоомжийг сурталчилан таниулах, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалд даатгуулахын ач тусыг ойлгуулах, НДТХ-д орсон өөрчлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт, шимтгэлийн хувь хэмжээний талаарх мэдээллийг аж ахуй нэгж байгууллага, иргэд даатгуулагчдад хүргэж тэдний нийгмийн баталгааг хангах үүднээс 5 удаагийн сургалт, facebook, Live, цахим мэдээллийн хэрэгслээр хийж 405 хүнийг хамруулан тэдний асуусан асуултад хариулж, тэдний санал хүсэлтийг авч ажилласан.

4.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэлт, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Эрүүл мэндийн даатгалд албан журмын даатгуулагч- 3065,8 сая, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчдаас 557,1 сая буюу нийт 3622,9 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгөөс 3659,2 сая төгрөг оруулж 7 хоног бүр төв санд бүрэн төвлөрүүлж ажилласан.

Орлого		
2022 он		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн%
5151,4	2908,5	56,5%
2023 он		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн %
3622,9	3659,2	101,0%



4.3 Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.

Сангийн зарлагын батлагдсан төлөвлөгөө 63650,7 сая төгрөг. НД-ын 4 сан тус бүр дээр 78,8%-96,8%-ийн гүйцэтгэлтэй гарч нийт 60825,1 сая төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд багтаан зарцуулж ажилласан байна. Эдийн засгийн ангилал бүрээр гүйлгээ

хийхийн өмнө өссөн дүнгээр батлагдсан төсөвт багтаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

НДСангуудын зарлагын төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:

/сая төг/

Д/д	Сангууд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Тэтгэвэр	59980,9	57798,9	96,4
2	Тэтгэмж	2858,6	2268,7	79,3
3	ҮОМШӨ	153,3	120,8	78,8
4	Ажилгүйдэл	657,9	636,7	96,8
Дүн		63650,7	60825,1	96,0


Тэтгэвэрт 8394 хүнд 57,9 сая төгрөг, тэтгэжмид 1819 хүнд 2268,7 сая, үомшө сангаас тэтгэвэр 17 хүнд 120,8 сая, ажилгүйдлийн сангаас 245 хүнд 636,7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг анхан шатны баримтад үндэслэн батлагдсан төлөвлөгөөний хүрээнд багтаан зарцуулж төсвийн сахилгыг чанд сахин ажиллаж мөн сумдын бүх тэтгэвэр, тэтгэмжийг хэлтэст хянаж үе шаттай давхар хяналтыг тавин ажиллаж Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

4.4 Нийгмийн даатгалын хамралтын талаар

Нийгмийн даатгалд 530 аж ахуй нэгж байгууллага, 6935 албан журмын даатгуулагч, 3785 сайн дурын даатгуулагч, эрүүл мэндийн даатгалд малчин- 4208, оюутан-171, ажилгүй –1345 нийт 16444 даатгуулагчийг тус тус хамруулсан. Татварын алба, Статистикийн хэлтсээс бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын судалгааг албан ёсоор авч тулгалт хийж нийгмийн даатгалд хамрагдаагүй ААН-ийг сумаар гарган хамруулах ажлыг зохион байгуулж энэ онд 30 аж ахуй нэгж байгууллага, албан журмын даатгуулагч 227, сайн дурын даатгуулагч 809-ийг шинээр хамруулж тэдний хууль ёсны эрх ашиг, нийгмийн баталгааг нь ханган ажилласан байна. Хамралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад: аж ахуй нэгжийн тоо 3-аар албан журмын даатгуулагчийн тоо 1-р буюу 1,0%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Харьцуулалт хийсэн хугацаа	Нийт ажил олгогчийн тоо	Албан журмын даатгуулагчдын тоо
2022 он	527	6934
2023 он	530	6935
Өсөлт бууралт	+3	+1

Графикаар харуулбал:




Эрүүл мэндийн даатгалын хамралтын талаар.

№	Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Малчин	7522	5870	78,0
2	Оюутан	1000	171	17,1
3	Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд	1066	1345	126,2
	Нийт	9588	7386	77,0%

ЭМД-ын орлогын төлвөлөгөөг 101%-иар биелүүлж, хамралт 77.0%-ийн биелэлттэй байна. ЭМД-ын сангийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 750,7 саяар буюу 25,8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хамралт		
2022 он		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн%
9420	6555	69,6%
2023 он		
Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн %
9588	7386	77,0%



4.5 НББийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн анхан болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах ажлыг зохион байгуулж хянаж нэгтгэн тогтоосон хугацаанд НД-ын төв байгууллагад хүргүүлэх.

Нийгмийн даатгалын сангийн анхан болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах ажлыг зөв удирдан зохион байгуулсны үр дүнд СБГазраас ирүүлсэн тайлан тушаах хуваарьт хугацаанд дараах тайлангуудыг үнэн зөв чанартай гаргаж хугацаанд нь хүргүүлж шалгуулсан. Үүнд:

5.1 Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн -1 тайланг 4 удаа

5.2 “Plastic” програмаар хөрвүүлсэн нэгтгэсэн тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн – 1 тайланг 4 удаа

5.3. Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-1 тайланг 4 удаа

5.4. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-1 тайланг 4 удаа

5.5. Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-2 тайланг 8 удаа

4.6 Сарын мэдээний талаар:

Сангийн орлого зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ гаргахад баримтлах заавар, анхаарах асуудлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сар бүр 15 сумдаас холбогдон мэдээллийн баазад шууд шивж нэгтгэн боловсруулж өгдөг.

5.6. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-1 мэдээг 12 удаа

5.7. Нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-1 мэдээг 12 удаа

5.8. Нийгмийн даатгалын сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн-1 мэдээг 12 удаа

5.9 ЭМД-ын сангийн орлогын болон хамралтын мэдээ- 2 мэдээг тус бүр 12 удаа, нийт 60 мэдээ тайланг хугацаанд нь чанартай үнэн зөв гаргаж өгсөн.

4.7. Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, жилийн эцсийн тайландаа аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажиллах талаар

Аймгийн Аудитын газраас санхүүгийн тайланд аудит хийлгэх бэлтгэл ажлыг хангуулахаар ирүүлсэн 36 нэр төрлийн судалгааг санхүүгийн тайлан баримт материалд үндэслэн үнэн зөв гаргаж хугацаанд нь хүргүүлсэн. 2022 оны жилийн эцсийн Нийгмийн даатгалын байгууллагын нэгдсэн санхүүгийн тайлан, баримт материалыг аудит хийлгэх хуваарьт хугацаанд хүргүүлсэн. Аудит хийх явцад асууж тодруулах, тайлбар хийх зэргээр хамтран ажилласан. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаас нэг албан шаардлага авч, “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” санал дүгнэлтийг авсан. Албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргүүлж дахин зөрчил гаргахгүй ажиллаж байна. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайланг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж, Аудитлагдсан санхүүгийн тайланг бүрэн эхээр нь шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь оруулсан.

4.8 Банкуудтай хамтран ажиллах гэрээг байгуулж, дүгнэн, үр дүнг тооцож ажиллах, тайланг НДЕГ-т хүргүүлэх талаар

НДЕГазрын даргын 2023 оны 03 дугаар саын 12-ны өдрийн 5/404 тоот Гэрээ хүргүүлэх тухай албан бичгээр ирсэн арилжааны банкттай хамтран ажиллах гэрээг мөрдөж ажиллаж байна. Энэ онд гэрээнд шинээр тусгагдсан заалтуудыг байцаагч ажилтнуудад танилцуулж бүх сумдад хүргүүлэн хэрэгжүүлж байна. Төрийн банк болон ХААН банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хагас жилээр дүгнэн хүргүүлсэн. Жилийн эцсийн гэрээний хэрэгжилтийг гэрээнд заасан хугацаанд талууд гэрээний заалт бүрээр харилцан дүгнэж ажиллана.

4.9 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж оны эхний үлдэгдлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хүрлээр хэлэлцэх

Шимтгэлийн авлагыг бууруулах төлөвлөгөөний дагуу данс хаасан-6 ажил олгогчийн 378.8 сая төгрөг, албан шаардлага хүргүүлсэн 21 ажил олгогчийн 51.2 сая төгрөг, График байгуулсан 21 ажил олгогчийн 210.6 сая төгрөг нийт 45 ажил олгогчийн 544,7 сая төгрөг

буюу 73,2%-ийг оны эхний авлагаас барагдуулсан байна. Хагас жилээр 721,7 сая төгрөгийн авлагатай байна.

б) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлсэн шимтгэлийн авлага байхгүй болно

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжсэн хугацаандаа төлөөгүй шимтгэлд оногдуулсан алдангийн авлага байхгүй болно.

5. Хэлтсийн үйл ажиллагааны зардлын талаар:

2023 онд 1092,4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас цалин хөлс нэмэгдэл урамшилд 762,8 сая, ажил олгогчийн ндш-д 95,3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд-40,5 сая, хангамж бараа материалын зардалд-16,4 сая, томилолт зочны зардалд- 5,8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд- 3,3 сая, эд хогшил урсгал засврын зардалд 2,4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд- 1,9 сая, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 75,5 сая нийт 1003,9 сая төгрөгийг эдийн засгийн ангиллаар зарцуулан ажиллаж байна.

НДҮЗ-ийн тогтоолоор батлагдсан төсөл төсөөлөл боловсруулахад баримтлах аргачлалын дагуу боловсруулан нэгтгэж хянуулсан. Төсөв төсөөллийг статистик судалгаа, өмнөх жилүүдийн гүйцэтгэл, ХБГ, татвар, улсын бүртгэлийн судалгаа, тухайн үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, журамд нийцүүлэн гаргасан.

Анхан шатны баримт бүрдүүлэх, бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, орлого, зарлагын гүйлгээг хууль журмын дагуу гаргаж бүртгэлээр тавих хяналтыг тогтмол хийж ажилласнаар улирлын тайланг хугацаанд нь чанартай гаргаж НДЕГазарт хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой сарын мэдээг НДЕГазарт 11, шилэн дансны мэдээлэлд 11, улирлын тайлан 3, НДШ-ийн тайланг 11, татварын тайланг 3 удаа тус тус гарган ажиллаж байна.

Анхан шатны бүртгэлийг үнэн зөв стандартын дагуу маягтыг хөтөлдөг, эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгадаг. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг хагас бүтэн жилээр тооллогын комиссоор тоолуулж, үнэт цаасны тооллогыг улирал бүр НДЕГазартай тооцоо нийлж тайлан тэнцэлд тусгуулан ажиллаж байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС